

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

2025 оны 08 дугаар сарын 15

“ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР”-ЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН
ГАЗРЫН ДАРГА



Г.БАЯРСАЙХАН

Улаанбаатар хот
2025 он

ӨМНӨТГӨЛ

Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар (цаашид “газар” гэх) нь 2024-2028 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн төлөвлөгөөг боловсруулан, эрх бүхий байгууллага болох Төсвийн ерөнхийлөн захирагч, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч танд өргөн мэдүүлж байна.

Газар нь нийслэлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, хот байгуулалтын уялдаа холбоо, зохион байгуулалтыг хангах чиглэлээр дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд: Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот дахин хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилтэд захиалагчийн хяналт тавих, зохион байгуулалтын нэгдмэл байдал хангах зэрэг багтана.


Газрын стратегийн төлөвлөгөө нь нутгийн захиргааны байгууллагын зорилго, чиг үүргийг тодорхойлсон бодлогын баримт бичиг бөгөөд хэрэгжилтдээ дараах хууль, эрх зүйн баримт бичгийг үндэслэл болгоно. Үүнд: Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Автозамын тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, мөн Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэрүүд, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг мөрдлөг болгон ажиллана.

Тус Газрын алба, хэлтэс бүр стратеги төлөвлөгөөг дотоод үйл ажиллагаандаа тусгаж, жил бүрийн үр дүнгийн гэрээ, журам, тайлагналд суурилан хэрэгжүүлэх бөгөөд иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг тасралтгүй сайжруулах, байгууллагын үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэхийг зорин ажиллах болно.

Мөн газрын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зарчмыг баримтлан, стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх, жилийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийн явцад гарсан ололт амжилт, хүндрэл бэрхшээлийг тухай бүр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид тайлагнах бөгөөд иргэд, олон нийтийн өмнө нээлттэй, ил тод байдлыг ханган ажиллана.

НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГА

Г.БАЯРСАЙХАН



АГУУЛГА

НЭГ.	НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	1
ХОЁР.	МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	1
ГУРАВ.	АЛСЫН ХАРАА	10
ДӨРӨВ.	ЭРХЭМ ЗОРИЛГО	10
ТАВ.	ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	11
ЗУРГАА.	СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	18
ДОЛОО.	БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ.....	26

НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН "2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ"

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Хот байгуулалтын тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай, Барилгын тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д зааснаар "Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна" гэж тусгасан. Энэ хүрээнд Засгийн газрын 2020 оны "Стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам батлах тухай" 216 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг шинэчлэн баталсан. "Стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын дагуу Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, "Хот байгуулалт, хотын стандартын газар"-ын 2024-2028 оны дунд хугацааны хөгжлийн бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх үндсэн баримт бичиг болох стратегийн төлөвлөгөөг дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулахаар тусгасан.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2021-2025 оны үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/08 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхээр Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулав.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Хуулиар тусгайлан олгосон газрын үйл ажиллагаанд хамаарах эрх үүрэг

Нийслэлийн хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх, зохион байгуулах ажлын хүрээнд хүн амын нутагшилт, суурьшил болон харьцангуй бие даан хөгжих бүс нутгийн хөгжлийн зохистой бүтэц бүрдүүлэх, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээ болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн ажил, Нийслэлийн Ерөнхий архитекторын эрх үүргийн дагуу хууль тогтоомжоор олгосон эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 1. Мандатын шинжилгээ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		20
Үүнээс	Тухайн салбарын хуулийн тоо	10
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	10
Ерөнхий чиг үүрэг-1: <u>Хот байгуулалтын тухай хууль</u>		

8 дугаар зүйл. Аймаг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: 8.1.1. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хот, тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлах	4.1.Газар нь Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалт, төлөвлөлт, барилгын талаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хотын стандартын тогтолцоог хөгжүүлж, иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг хуулийн хүрээнд шуурхай, нэг мөр барагдуулж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 4.1.1.хот байгуулалтын чиглэлээр; 4.1.2.дагуул хот, дэд төвийн төлөвлөлтийн чиглэлээр; 4.1.3.нийслэл хотод баригдаж буй барилга байгууламжийн чиглэлээр; 4.1.4.инженерийн шугам сүлжээний чиглэлээр; 4.1.5.хотын стандарт, норм ба дүрмийг боловсронгуй болгох чиглэлээр;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Барилга, хот байгуулалтын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ҮЧҮ-2: 8.1.2. Хот байгуулалтын баримт бичигт тусгагдсан төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэх;	4.1.1.2.нийслэлийн хэмжээнд хот төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх техник, эдийн засгийн үндэслэл, төсөл, хөтөлбөрийн ажлын даалгавар боловсруулах, санал өгөх, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах ажлыг зохион байгуулах;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ҮЧҮ-3: 8.1.5. Бүс нутгийн хөгжлийн төслийн үндсэн шийдэлтэй уялдуулан орон нутгийн зэрэглэлтэй хот болон тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах	4.1.1.3.орон нутгийн зэрэглэлтэй хот, суурин (дагуул хот, дэд төв)-ы ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг хангах;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ҮЧҮ-4: 8.1.6. Нийслэл, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;	4.1.1.1.хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалт, газрын харилцааны бодлого боловсруулахад санал гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ҮЧҮ-5: 8.1.7. Шинэ хороолол, хотхон, гэр хороолол, хотын хуучин хэсгийг шинэчлэн барилгажуулах шийдвэр гаргах.	4.1.1.6.хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн байршлыг тогтоох, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн ажлын даалгавар, барилгажилтын төсөл батлуулах;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг

		даргын Тамгын газар, Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, УБГХХХОДХТ
Ерөнхий чиг үүрэг-2 9 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх		
ҮЧҮ-1:9.1.2. Аймаг, нийслэлийн ерөнхий архитектурыг 4 жилийн хугацаагаар томилох;	6.3.Газрын хариуцсан чиг үүрэгт хамаарах нийслэлийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах, батлуулах, салбар дундын уялдааг хангах, зохицуулах, хяналт тавих, захиргааны эрх хэмжээний асуудлаар зөвлөмж, чиглэл өгөх, мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргийн удирдлагыг Нийслэлийн Ерөнхий архитектор болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ.	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ҮЧҮ-2: 9.1.3. Ерөнхий архитектораар удирдуулсан хот байгуулалт, барилга захиалагчийн албыг байгуулах;	6.5.Нийслэл хотын Ерөнхий архитектор нь Хот байгуулалтын тухай хууль, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Аймаг, нийслэлийн Ерөнхий архитекторын дүрэм” болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ба энэхүү чиг үүргийн хүрээнд тушаал, шаардлагатай бусад шийдвэрийг гаргана.	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ҮЧҮ-3: 9.1.4. Аймаг, нийслэлийн хөгжлийн төсөл, хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгол, шинэчлэл хийх асуудлыг санаачлан зохион байгуулах;	4.1.1.2.нийслэлийн хэмжээнд хот төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх техник, эдийн засгийн үндэслэл, төсөл, хөтөлбөрийн ажлын даалгавар боловсруулах, санал өгөх, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах ажлыг зохион байгуулах;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
	4.1.1.4.хот байгуулалтын баримт бичгийн зургийн даалгаврыг боловсруулах, гэрээ байгуулах, зураг төслийн боловсруулалт, хэрэгжилтийн шатанд хяналт тавих; 4.1.2.1.дагуул хот, эдийн засгийн тусгай бүс, дэд төвийг байгуулах, хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд баримт бичгийн төслийг боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг	

	зохион байгуулах, санал өгөх, шинжлэх ухааны үндэслэл бүхий техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг зохион байгуулж, суурь судалгаа хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлүүлэх;	
ҮЧҮ-4: 9.1.5. Хот байгуулалтын үйл ажиллагаа болон газар ашиглалт, хамгаалалтад хяналт тавих;	4.1.1.1.хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалт, газрын харилцааны бодлого боловсруулахад санал гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих; 7.1.15. барилга байгууламжийн байршил тогтоох, загвар зураг батлуулах үйл ажиллагааг зохион байгуулах, нэгдсэн бүртгэл хөтлөх, хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хот байгуулалтын мэдээллийн менежментийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Хяналт шалгалтын газар
ҮЧҮ-5: 9.1.6. Хот байгуулалтын чиглэлээр хийгдсэн ажлын талаарх тайланг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жилд нэг удаа ирүүлэх.	Газрын дүрмийн 6.5. Газрын хариуцсан чиг үүргийн хүрээнд нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, чиг үүргийн удирдлагаас өгсөн зөвлөмж чиглэлийн дагуу ажиллах, үйл явц, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнах, газрыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах шугаман удирдлагыг газрын дарга хэрэгжүүлнэ.	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
Ерөнхий чиг үүрэг-3 10 дугаар зүйл. Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын эрх, үүрэг		
ҮЧҮ-1: 10.1.1. Хот байгуулалтын салбарын норматив, эрх зүйн бусад актын төсөл болон тэдгээрийг боловсруулах, өөрчлөх тухай санал оруулах;	4.1.5.1.нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн хотын стандартын тогтолцоог боловсруулах ажлыг зохион байгуулах, Ерөнхий архитектораас өгсөн чиглэлийн дагуу норм ба дүрэмд санал өгч оролцох, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэглэх, дагаж мөрдөхөд чиглэсэн удирдамж, арга зүйн тогтолцоог хөгжүүлэх; 7.1.10.хариуцсан чиг үүрэгт хамаарах асуудлаар удирдах албан тушаалтанд хандаж санал гаргах, шийдвэрлүүлэх;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

ҮЧҮ-2: 10.1.2. Орон нутаг дахь хот байгуулалтын бодлого боловсруулахад санал гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	4.1.1.1.хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалт, газрын харилцааны бодлого боловсруулахад санал гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
	4.1.4.1.инженерийн шугам сүлжээ болон авто замын төлөвлөлтийг хот байгуулалтын бодлоготой уялдуулж төлөвлөх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	
	5.5.Газар нь хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг, даалгавар, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааны явц, гүйцэтгэлийн үр дүнг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана.	
ҮЧҮ-4: 10.1.4. Хот суурины нутаг дэвсгэрт хот байгуулалтын кадастр хөтлөх, хот байгуулалтын архивын санг бүрдүүлэх;	4.1.3.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт тэг тэнхлэгийн акт, инженерийн шугам сүлжээ, барилга, байгууламжийн байр зүйн гүйцэтгэлийн зургийг стандартын дагуу бүртгэж хот байгуулалтын архивын санг бүрдүүлэх, тоон болон зурган мэдээллээр үйлчлэх;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Харьяа агентлагууд, Хангагч байгууллагууд
	4.1.4.2.инженерийн шугам сүлжээ болон авто замын дэд бүтцийн барилга, байгууламжийн ажлын даалгавар боловсруулж батлуулах, төлөвлөлтийн трасс зөвшилцөх, мэдээллийн санд бүртгэж хот байгуулалтын архивын санг бүрдүүлэх.	
	4.1.5.2.хотын стандартын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх;	
	7.1.15. барилга байгууламжийн байршил тогтоох, загвар зураг батлуулах үйл ажиллагааг зохион байгуулах, нэгдсэн бүртгэл хөтлөх, хот байгуулалтын архивын санг бүрдүүлэх;	
	7.1.16. Хот байгуулалтын архивын санг хадгалах, хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хот байгуулалтын цахим системийг хөгжүүлэх	
ҮЧҮ-5: 10.1.5. Орон нутгийн хот байгуулалтын үйл ажиллагааг зохицуулж, Хот	7.1.11.хариуцсан чиг үүрэгт хамаарах асуудлаар удирдах албан тушаалтан, холбогдох	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар,

байгуулалт, барилга захиалагчийн албыг өдөр тутмын мэргэжил арга зүйн удирдлагаар хангах	байгууллага, албан хаагчдыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах;	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
ҮЧҮ-6: 10.1.6. Барилга байгууламжийг барьж байгуулахаас өмнө тухайн газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гудамжны нэр, барилгын дугаарыг тогтоож, газрын кадастрын бүртгэлд оруулах ажлыг зохион байгуулах;	4.1.3.3.Гудамж, зам талбайг нэршүүлэх, нэрэмжит болгох ажлыг зохион байгуулах, барилга, байгууламжийн мэдээллийн санд суурилсан бүртгэл хөтлөх, хаяг дугаар олгох;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар
ҮЧҮ-7: 10.1.7. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх;	4.1.1.2.нийслэлийн хэмжээнд хот төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх техник, эдийн засгийн үндэслэл, төсөл, хөтөлбөрийн ажлын даалгавар боловсруулах, санал өгөх, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах ажлыг зохион байгуулах	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
ҮЧҮ-8: 10.1.8. Инженерийн бэлтгэл ажилд хяналт тавих.	4.1.4.1.инженерийн шугам сүлжээ болон авто замын төлөвлөлтийг хот байгуулалтын бодлоготой уялдуулж төлөвлөх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх; 4.1.4.2.инженерийн шугам сүлжээ болон авто замын дэд бүтцийн барилга, байгууламжийн ажлын даалгавар боловсруулж батлуулах, төлөвлөлтийн трасс зөвшилцөх, мэдээллийн санд бүртгэх.	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Ус сувгийг удирдах газар
Ерөнхий чиг үүрэг-4: 11 дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичиг 11.5. Дор дурдсан этгээд хот байгуулалтын баримт бичгийн захиалагч байна:		
ҮЧҮ-1: 11.5.2. Аймаг, нийслэл, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын захиалагч нь тухайн шатны Засаг дарга, хот, тосгоны захирагч.	4.1.1.1.хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалт, газрын харилцааны бодлого боловсруулахад санал гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих; 4.1.1.3.орон нутгийн зэрэглэлтэй хот, суурин (дагуул хот, дэд төв) ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг хангах; Газрын дүрмийн 4.1.4. Орон нутгийн зэрэглэлтэй хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, дагуул хот, эдийн засгийн тусгай	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

	бүсийн ерөнхий төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг хангах	
Ерөнхий чиг үүрэг-5: 17 дугаар зүйл. Олон нийтийн санал авах		
17.1. Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой төлөвлөлтийн зарчмыг тусгаж ажиллана.		
ҮЧҮ-1: 17.2. Хот, тосгоны захирагч нь хот төлөвлөлтийг хэрэгжүүлэхдээ иргэд болон холбогдох мэргэжлийн хүмүүсийн оновчтой саналыг авч хот төлөвлөлтөд тусгана.	Газрын дүрмийн 4.1.1. Хот байгуулалтын баримт бичгийн зургийн даалгаврыг боловсруулах, гэрээ байгуулах, зураг төслийн боловсруулалт, хэрэгжилтийн шатанд хяналт тавих;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Хот төлөвлөлт, судалгааны институт
Ерөнхий чиг үүрэг-5: <u>Барилгын тухай хууль</u>		
27 дугаар зүйл. Барилгын ажлын зөвшөөрөл олгох үйл ажиллагаа		
ҮЧҮ-1: 27.1. Энэ хуулийн 35.1-д заасан байгууллага барилгын ажлын зөвшөөрлийг олгоно.	4.1.3.1.барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн баримт бичгийн бүрдлийг хангуулж, барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох, сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
Ерөнхий чиг үүрэг-6: 35 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх		
ҮЧҮ-1: 35.1.3. Барилга байгууламжийн байршил тогтоох, газар олголт, загвар зураг батлах болон техникийн нөхцөл олгох үйл ажиллагааг зохион байгуулж, нэгдсэн бүртгэл хөтлөх, хадгалах, мэдээлэл түүний аюулгүй байдлыг хангах, мэдээллийн сангийн байнгын үйл ажиллагааг эрхлэх, хяналт тавих;	7.1.15. барилга байгууламжийн байршил тогтоох, загвар зураг батлуулах үйл ажиллагааг зохион байгуулах, нэгдсэн бүртгэл хөтлөх, хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хот байгуулалтын мэдээллийн менежментийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Харьяа агентлагууд
ҮЧҮ-2: 35.1.4. Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах;	4.1.3.2.барилга байгууламжийг паспортжуулах, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Хотын стандарт, хяналтын газар
ҮЧҮ-3: 35.1.8. Барилгын тухай хуулийн 35.1.3, 35.1.4, 35.1.6-д заасан үйл ажиллагаатай холбоотой хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэн, нэг цэгийн үйлчилгээгээр зохион байгуулах.	3.1.1.байгууллагын үнэ цэн, нэр хүндийг дээшлүүлж, төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ҮЧҮ-4: 46.1.13. Барилгын нүүр талыг өөрчлөх тохиолдолд аймаг, нийслэлийн ерөнхий архитектортай зөвшилцөх;	4.1.1.5.барилга байгууламжийн гадна фасадын шийдэл бүхий Архитектур төлөвлөлтийн даалгавар, авто зам, замын болон дэд бүтцийн барилга, байгууламжийн төлөвлөлтийн даалгавар, нийтийн эдэлбэр газрын тохижилтын ажлын	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар,

	даалгавар боловсруулах, Загвар зураг батлуулах;	
Ерөнхий чиг үүрэг-7: <u>Геозеи, зураг зүйн тухай</u> 5 дугаар зүйл. Геозеи, зураг зүйн үйл ажиллагааны талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг		
ҮЧҮ-1: 5.8.2. Нутаг дэвсгэртээ хамаарах байр зүйн зураг, зураг зүйн бүтээлд тусгагдах газар зүйн нэр, хил, шинээр байгуулагдсан болон өөрчлөгдсөн объектын талаарх мэдээлэл, геозеийн байнгын цэг, тэмдэгтийн хадгалалт, хамгаалалт, шинэчлэлт, баяжуулалтыг хийж, хяналт тавьж, дараа жилийн 02 сарын 01-ний өдрийн дотор архивын эх материалыг геозеи, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;	4.1.3.4. Инженерийн дэд бүтэц бүхий байр зүйн болон дэвсгэр зургийн өөрчлөлтийг мэдээллийн сангийн стандартын дагуу хариуцан хөтөлж, шинэчлэлт, баяжуулалтыг тухай бүр хийж, хяналт тавьж, тайлагнах;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар,
Ерөнхий чиг үүрэг-8: <u>Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай</u> 11 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх		
ҮЧҮ-1: 11.1.1. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн төсөл санаачлах, боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	4.1.1.6.хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн байршлыг тогтоох, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн ажлын даалгавар, барилгажилтын төсөл батлуулах;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Орон сууцны бодлогын газар
ҮЧҮ-6: 14.4.2. Хот, суурин газар, дүүрэг, хорооллын чанартай инженерийн болон нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламж барих;	Газрын дүрмийн 4.1.8. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн ажлын даалгавар, барилгажилтын төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах, батлуулах Газрын дүрмийн 4.1.6. Барилга байгууламжийн Архитектур төлөвлөлтийн даалгавар, авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар, нийтийн эдэлбэр газрын тохижилтын ажлын даалгавар боловсруулах, загвар зураг батлуулах	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
Ерөнхий чиг үүрэг-8: <u>Газрын тухай хууль</u> 20 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын нийтлэг бүрэн эрх		
ҮЧҮ-1: 20.1.2. тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион	4.1.1.2.нийслэлийн хэмжээнд хот төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх техник, эдийн засгийн үндэслэл, төсөл, хөтөлбөрийн ажлын	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Газар

байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах;	даалгавар боловсруулах, санал өгөх, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах ажлыг зохион байгуулах;	зохион байгуулалтын алба
Ерөнхий чиг үүрэг-9: Орон сууцны тухай 8 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх		
8.2.3. Орон сууцны тооллого, паспортжуулах ажлыг зохион байгуулан мэдээллийн санг эрхлэн хөтөлж, холбогдох мэдээллийг орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад өгөх;	4.1.3.2.барилга байгууламжийг паспортжуулах, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Хяналт шалгалтын газар
Ерөнхий чиг үүрэг-10: Хаягжуулалтын тухай 4 дүгээр зүйл. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулах		
ҮЧҮ-1: 4.1. Гудамж, зам, талбай болон өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн үл хөдлөх эд хөрөнгөд байршлын хаяг олгоно.	4.1.3.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр гудамж, зам талбайг нэршүүлэх, нэрэмжит болгох ажлыг зохион байгуулах, барилга, байгууламжид хаяг дугаар олгох, улсын хаягийн нэгдсэн системд бүртгэх,	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Нэрийн комисс
ҮЧҮ-2: 4.5. Гудамж, зам, талбайг давхардахгүй байдлаар нэрлэж, дугаарлана.		
Ерөнхий чиг үүрэг-11: Усны тухай 12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх		
ҮЧҮ-1: 12.1.4. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах;	4.1.4.1.инженерийн шугам сүлжээ болон авто замын төлөвлөлтийг хот байгуулалтын бодлоготой уялдуулж төлөвлөх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Ус сувгийн удирдах газар
Ерөнхий чиг үүрэг-12: Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай 7 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх		
ҮЧҮ-1: 7.1.2. нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох;	4.1.4.2.инженерийн шугам сүлжээ болон авто замын дэд бүтцийн барилга, байгууламжийн ажлын даалгавар боловсруулж батлуулах, төлөвлөлтийн трасс зөвшилцөх, мэдээллийн санд бүртгэх.	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Ус сувгийн удирдах газар
ҮЧҮ-2: 8.1.1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын	4.1.4.1.инженерийн шугам сүлжээ болон авто замын төлөвлөлтийг хот байгуулалтын бодлоготой	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар,

тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	уялдуулж төлөвлөх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	Ус сувгийн удирдах газар
Ерөнхий чиг үүрэг-13: Сэргээгдэх эрчим хүчний тухай 5 дугаар зүйл. Сэргээгдэх эрчим хүчний талаарх төрийн байгууллагын чиг үүрэг		
ҮЧҮ-1: 5.5.1. Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг байршуулах газрыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах;	4.1.4.1. инженерийн шугам сүлжээ болон авто замын төлөвлөлтийг хот байгуулалтын бодлоготой уялдуулж төлөвлөх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
Ерөнхий чиг үүрэг-14: Гамшгаас хамгаалах тухай 32 дугаар зүйл. Засаг даргын бүрэн эрх		
ҮЧҮ-1: 32.1.10. Орон нутгийн онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх;	4.1.3.2. барилга байгууламжийг паспортжуулах, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх;	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Онцгой байдлын газар

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

"НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙГ ХӨТӨЛНӨ"

(Хөтөлж өнгөөлөх, тэргүүлэх, Хөтөлж чиглүүлэх, Хөтөлж бүртгэх, Хөтлөгч хүч байх)

Үзэл баримтлал:

- ❖ Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаа "Чанарын удирдлагын тогтолцоо", үйл ажиллагааны, хэрэгжилт, үр дүн, үйлчилгээний чанараар тэргүүлэгч "МАНЛАЙЛАГЧ БАЙГУУЛЛАГА";
- ❖ Нийслэлийн хэмжээнд хот төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, тодотгох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, хот байгуулалтын үйл ажиллагааг зохицуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, чиглэл өгөх үүрэг бүхий "ЧИГЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА";
- ❖ Нийслэлийн хэмжээнд хот байгуулалт, төлөвлөлтийн мэдээллийн санг хөтлөх, дундын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, мэдээллийн санг бүрдүүлэгч байгууллагуудтай хамтран иргэн, хуулийн этгээдэд хот байгуулалтын мэдээллээр үйлчлэх, мэдээллийн сангийн удирдлага зохион байгуулалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах үүрэг бүхий "ХӨТЛӨГЧ БАЙГУУЛЛАГА";
- ❖ Хотын стандартын тогтолцоог хөгжүүлж хотын засаглал, бүтээн байгуулалт, бүтээгдэхүүн, үйлчилгээнд дэлхийн жишигт хүрсэн чанарыг нэвтрүүлж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах "ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА";

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн, нийслэлийн нийгэм, эдийн засгийн нөөц боломжид тулгуурлан иргэдийн оролцоотой төлөвлөх, хотын стандартын тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэн нийслэл Улаанбаатар хотын дагуул хот, эдийн засгийн тусгай бүс байгуулах, хот байгуулалтын үйл ажиллагааг орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан хурдан шуурхай, хүртээмжтэй байдлаар зохион байгуулахад оршино.

Бидний эрхэмлэх үнэт зүйлс:

- ❖ Хууль ёсыг эрхэмлэх: Төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах болон төрийн албаны бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн сахина.
- ❖ Ёс зүйг эрхэмлэх: Төрийн албаны ёс зүйн үнэт зүйлс, зарчим, хэм хэмжээг сахин ажиллана.
- ❖ Шударга ёсыг эрхэмлэх: Газрын үйл ажиллагаа явуулах, үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахдаа аливаа хэлбэрээр ялгаварлахгүй, ямарваа хөндлөнгийн нөлөөлөлд орохгүй, ашиг сонирхлын аливаа зөрчилд автахгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцүүлж, чин шударгаар ажиллана.
- ❖ Шударга байдлыг эрхэмлэх: Төрийн албанд ямагт чин сэтгэлээс хандаж, албан үүргээ аль болох үр бүтээлтэй, илүү чанартай гүйцэтгэх талаар санаачилга, идэвх зүтгэл гарган, иргэдэд төрийн үйлчилгээг бүрэн дүүрэн үзүүлэх талаар боломжтой бүх нөөц бололцоог дүүрэн ашиглаж ажиллана.
- ❖ Мэдлэгийг эрхэмлэх: Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай мэдлэгтэй байж, түүнийгээ цаг үеийн эрэлт шаардлагад нийцүүлэн мэдлэгээ байнга хөгжүүлнэ.
- ❖ Чадварыг эрхэмлэх: Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд зохистой арга барил, үр чадвар, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг эзэмшиж, түүнийгээ ажлаа чадамгай, үр бүтээлтэй гүйцэтгэхэд ашиглана.
- ❖ Хариуцлага, ил тод байдлыг эрхэмлэх: Хууль тогтоомжийн хүрээнд мэдээллийн ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан, ажилдаа эзэн болж түүнийхээ гүйцэтгэлийн үр дүнг биечлэн хариуцна.
- ❖ Бүтээлч байдлыг эрхэмлэх: Хариуцсан ажлынхаа чиглэлээр шинийг эрэлхийлэх, шинэ ололт амжилтыг ажилдаа нэвтрүүлнэ.
- ❖ Багийн ажиллагааг эрхэмлэх: Бусдыг хүлээн зөвшөөрч цаг ямагт багийн ажиллагааг эрхэмлэн ажиллана.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Газрын тулгамдаж буй асуудал, зорилго, зорилт цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохоор СВОН шинжилгээг гадаад, дотоод орчны хүрээнд хийсэн.

ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Гадаад орчны шинжилгээнд улс төр, эдийн засаг, нийгэм соёл, технологи, хууль эрх зүй, байгаль орчны зүгээс үзүүлэх нөлөөллийг тодорхойлж эерэг боломж, ямар сөрөг нөлөөлөл, эрсдэл байгааг гаргахыг зорьсон болно.

ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Дотоод орчны шинжилгээг хийхдээ байгууллагын бүтэц, зохион байгуулалт, соёл, хүний нөөц (хүн, санхүү, техник, мэдээлэл) хийгээд технологийн үйл явц зэрэг хүчин зүйлсийн хүрээнд давуу ба сул талыг тодорхойлсон.

Хүснэгт. Дотоод ба Гадаад орчны шинжилгээний үр дүн /СВОН шинжилгээ/

ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж	
• Нийслэлийн Ерөнхий архитекторын эрх, үүрэг хэм хэмжээг хуулиар тусгайлан олгосон;	• Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын бүтэц зохион байгуулалт, ажлын уялдаа холбоо сул;

• Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгох, шинэчлэн боловсруулах хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих; • Нийслэлийн хэмжээнд хот байгуулалтын бодлого боловсруулахад санал гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, • Хот байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг хот төлөвлөлтийн харилцан уялдаа, бодлогоор хангах; • Нийслэлийн нутаг дэвсгэрт хот байгуулалтын архивын санг бүрдүүлэх, нэгдсэн мэдээллийн сан;\ • Нийслэлд тулгамдаж буй асуудлаар хот төлөвлөлтийн суурь судалгаа, төсөл хөтөлбөр шинээр санаачлан боловсруулах;	• Хот төлөвлөлтийн бодлогын баримт бичиг, зураг төслийн хэрэгжилт, гүйцэтгэлийн шатанд хяналт сул, алдаа дутагдал их; • Хот төлөвлөлтийн чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин бэлдэх, мэргэшүүлэх хүний нөөцийн бодлогоор хангах удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг сул; • Барилга, архитектур, хот төлөвлөлтийн чиглэлээр мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй төрийн албан хаагчдад урамшуулал олгох олгох эрхзүйн орчин сул; • Гадаадад мэргэжлийн чиглэлээр туршлага судлах сургалт, семинарт хамруулах үйл ажиллагаа багассан; • Чадварлаг боловсон хүчин төрийн албанд тогтвортой ажиллах боломж бага.
Байгууллагын бүтэц, зохион байгуулалт	
• Хот байгуулалтын баримт бичиг боловсруулалт, хэрэгжилт, Нийслэлийн нутаг дэвсгэрт баригдах барилга, авто зам, замын байгууламж, инженерийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөлтийн даалгавар боловсруулах үйл ажиллагааг хэлэлцэх чиг үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн хурлыг нээлттэй live хэлбэрээр зохион байгуулсан. • Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой хариуцсан чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсгүүдтэй; • Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, уян хатан, хүртээмжтэй, чанартай хүргэх хүний нөөцийн болон бүтэц зохион байгуулалтад орж иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн цахим үйлчилгээг нэвтрүүлсэн. • Хот байгуулалтын салбарт олон жилийн түүх, туршлагатай, мэргэжлийн боловсон хүчний залгамж чанартай, мэргэшсэн чадварлаг баг, хамт олон;	• Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чанарын удирдлага, зохион байгуулалт сул; • Нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, ажил үүргийн давхардал, ажлын ачаалал онцлогт тохирсон зохион байгуулалт дутмаг байдал; • Гаднын хөгжилтэй орнуудын хот байгуулалт, төлөвлөлтийн чиглэлийн байгууллагатай туршлага солилцох хамтын ажиллагаа сул; • Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хот байгуулалт, төлөвлөлтийн ач холбогдол болон шинээр санаачлан боловсруулсан судалгаа, төсөл хөтөлбөрүүдийг иргэд, олон нийтэд таниулах байнгын ажиллагаатай хэвлэл, мэдээлэл хариуцсан бүтэц, орон тоо дутмаг;
Байгууллагын соёл	
• Байгууллагын албан хаагчдыг эрүүл мэнд, бие бялдар, дотоод уур амьсгал, эв нэгдлийг бэхжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих арга хэмжээг тогтмол зохион байгуулах үүрэг бүхий байнгын ажиллагаатай ажлын хэсэг байгуулж хэвшсэн;	• Байгууллагын гадагш чиглэсэн үйлчилгээ болон дотоод үйл ажиллагаанд ашиглаж байгаа баримт бичгийн гүйцэтгэл сул; • Албан хаагчдын мэргэжлийн ёс зүй, төрийн албан хаагчийн имиж, хувийн соёл, зохион байгуулалт харилцан адилгүй байдал;

• Төрийн албаны нэр хүнд өсөж, иргэдийн хэрэгцээнд суурилсан, итгэл хүлээсэн төрийн үйлчилгээний соёл хэвшсэн байна. • Байгууллагын албан хаагчдын нийгмийн хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлдэг; • Байгууллагын дотоод уур амьсгал, эв нэгдлийг бэхжүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг	• Албан хаагчдын “Бүтээлч оновчтой санаа”-г идэвхжүүлэх, дэмжлэг үзүүлэх; • Төрийн үйлчилгээний чанарын стандарт бий болж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшсөн байна. • Нэгжүүдийн багаар ажиллах чадвар, хамтын ажиллагаа суларсан;
Нөөц /Хүн, санхүү, техник, мэдээлэл/	
• Нийт албан хаагчдын 66 нь улсад, 74 нь төрийн албанд 5-аас дээш жил ажилласан туршлагатай, • Нийт албан хаагчдын 38 нь зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй.	• Төрийн албан хаагч мэргэжлийн чиглэлээр мэргэших, мэргэжил дээшлүүлэхэд санхүү, хүний нөөцийн дэмжлэг сул; • Мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй албан хаагчдад урамшуулал олгох хууль эрхзүйн зохицуулалт муу; • Мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн, зөвлөх зэрэг, ажлын туршлага, ур чадвар, хамт олондоо хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг харгалзан мэргэжил, албан тушаалын үүрэг хариуцлага хүлээх, цалин хөлсний нэмэгдэл тооцох санхүүгийн зохицуулалт сул. • Орчин үеийн дэвшилтэт технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, хөрөнгө санхүү шийдвэрлүүлэх байдал; • Мэргэжлийн чиглэлийн программ хангамж албан ёсны зөвшөөрөлгүй ашиглах байдал ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлөх; • Албан хаагчдын компьютерын хүчин чадал, мэргэжлийн чиглэл, албан тушаалын чиг үүрэгтэй уялдаагүй хуваарилалт харилцан адилгүй байдал.
ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл
Улс төрийн нөлөөлөл	
• “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг батлагдсан нь улсын хэмжээнд төрийн байгууллагын бүх шатанд алсын хараа, зорилго, зорилт, хүрэх түвшин тодорхойлох; • Хот өөрийн бие даасан хууль, дүрэмтэй болгох; • Хот байгуулалт, төлөвлөлтийн салбарын бүтэц зохион байгуулалтыг тогтвортой, мэргэшсэн байдлыг хангах, улс төрийн намууд болон сонгуулийн үр дүнгээс хараат байх нөхцөлийг хангах; • Сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн албан хаагч тогтвортой ажиллах нөхцөл бүрдэж, төрийн албаны шатлан дэвшүүлэх тогтолцоо боловсронгуй болсон байна.	• Газрын бүтэц, удирдлага зохион байгуулалт сонгуулийн үр дүнтэй шууд хамааралтай байх; • Салбарын бүтцийн өөрчлөлт, удирдлага, зохион байгуулалтын богино хугацааны өөрчлөлт нь төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчимд сөргөөр нөлөөлөх; • Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын харилцан хамаарал, ажлын уялдаа холбоо алдагдах, чиг үүргийн давхардал гарах; • Улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр, үзэл баримтлал, аливаа бодлого шийдвэрүүд нь хот төлөвлөлтийн урт баримт бичгийн үзэл баримтлал, зарчимтай уялдаагүй байдал нь хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад сөрөг нөлөө үзүүлэх;

Эдийн засгийн нөлөөлөл	
